

**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үр нөлөө,
түүнийг сайжруулах арга зам**

**The Impact of Pre-Trial Hearings in Criminal
Proceedings and Proposals for Their Improvement**

Энх-Ялалтын Энхзул

Хууль зүйн бакалавр (LL.B.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль

Улаанбаатар хот, Монгол Улс

zulaa.yalalt@gmail.com

© E.Enkhzul, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)
(CC BY-NC 4.0)

[Товч утга]

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг манай улс хууль тогтоомждоо тусгасан нь сайн зүйл болсон. Үүнийг тодруулбал шүүхийн өмнөх шат нь мөрдөн шалгах зарчмын үндсэн дээр мөрдөн шалгах ажиллагаа явагддаг тул мөрдөгч, прокурор онцгой эрхтэйгээр яллагдагчийг гэм буруутай эсэхийг тогтоох зорилготойгоор нотлох баримтыг цуглуулж бэхжүүлдэг. Өмгөөлөгчийн хувьд мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримтыг хэрэгт хавсаргахаар хүсэлт гаргах зэрэг эрхээр хязгаарлагддаг. Шүүхийн өмнөх шат дахь талуудын эрх тэгш байдлыг хангах зорилгоор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хууль тогтоогчид оруулж ирсэн. Энэ шатанд л өмгөөлөгч яллагдагчийг цагаатгах талын баримт болон мөрдөн шалгах ажиллагааны зөрчил, хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг баримттайгаар хэлэлцэж, гэм буруугийн шүүх хуралдаанд эрх тэгш, тэнцвэртэйгээр бэлтгэх явдал юм. Гэтэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтын хэрэгжилтийн түвшин болоод үр дагаврын хувьд төдийлөн сайн үр дүн гарахгүй байгаатай холбогдуулан хэд хэдэн асуудлууд хуульч, эрх зүйчдийн дунд практикт тулгарах болсон юм. Тодруулбал шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг тухайлан нэг үе шат болгосон атлаа заавал дамжин өнгөрөх бус талуудын санал, хүсэлт эсхүл шүүгч өөрийн санаачилгаар хэлэлцүүлэхээр зохицуулах болсон нь эргээд хэлэлцүүлэг хийгдээгүй гэм бурууг эцэслэн шийдвэрлэхэд оролцогчийн эрхийг зөрчсөн болон хэргийг прокурорт буцаах үр дагаврыг бий болгодог. Энэ нь гэм буруугийн хэлэлцүүлгийн шатанд нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчмын хэрэгжилтэд нөлөөлдөг. Шүүгч өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг товлон зарлах нь тухайн хэргийн материалтай урьдчилсан танилцсан байдаг бөгөөд хэрэгт шаардагдах нотлох баримтыг бүрдүүлэхийг шаардаж, хэргийг прокурорт буцаах нь талуудын мэтгэлцээнд бус яллах хэв шинжтэй шүүхийн дүр зургийг бий болгох болсон юм.

[Түлхүүр үг]

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, Хэргийг прокурорт буцаах, Прокурорт даалгах, Хуулийн үзэл баримтлал.

I. Оршил

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг” гэх зохицуулалтыг оруулж ирсэн бөгөөд энэхүү зохицуулалт нь шүүхийн хэлэлцүүлгийн нэг үе шатыг бий болгосон юм. Энэ зохицуулалт нь хүний эрхийг дээдэлсэн, ардчилсан улсын хуульд тусгагдах зайлшгүй шаардлагатай зохицуулалт мөн бөгөөд тус зохицуулалтыг хуульд тусгасан нь дэвшилтэт алхам болсон гэж судлаачид дүгнэжээ¹. Монгол улсын эрүүгийн процессын үе үеийн хуулиудад шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа гэх зохицуулалтууд агуулагдсаар ирсэн бөгөөд яг тодорхой одооны хуульд тусгасан байдлаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг шиг тухайлан нэг үе шатыг бий болгоогүй байсан юм. Энэ үе шатанд ерөнхий байдлаар тухайн хэргийн бүрдэл хэсэг хангагдсан эсэх, шүүх хуралдааныг үргэлжлүүлэхэд аливаа саад бэрхшээл хэргийн хувьд байгаа эсэх, мөн оролцогчдын эрхийг хангах зэрэг 15 асуудлыг хэлэлцэх боломжтой байдлаар хууль тогтоогч хуульчилсан байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг манай улс хууль тогтоомждоо тусгасан нь сайн үр нөлөөтэй. Үүнийг тодруулбал шүүхийн өмнөх шат нь мөрдөн шалгах зарчмын үндсэн дээр мөрдөн шалгах ажиллагаа явагддаг тул мөрдөгч, прокурор онцгой эрхтэйгээр яллагдагчийг гэм буруутай эсэхийг тогтоох зорилготойгоор нотлох баримтыг цуглуулж бэхжүүлдэг. Өмгөөлөгчийн хувьд мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримтыг хэрэгт хавсаргахаар хүсэлт гаргах зэрэг эрхээр хязгаарлагддаг. Шүүхийн өмнөх шат дахь талуудын эрх тэгш байдлыг хангах зорилготой бөгөөд мэтгэлцэх боломжийг олгож байна. Энэ шатанд л өмгөөлөгч яллагдагчийг цагаатгах талын баримт болон мөрдөн шалгах ажиллагааны зөрчил, хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг баримттайгаар хэлэлцэж, гэм буруугийн шүүх хуралдаанд эрх тэгш, тэнцвэртэйгээр бэлтгэх явдал юм. Гэтэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтын хэрэгжилтийн түвшин болоод үр дагаврын хувьд төдийлөн сайн үр дүн гарахгүй байгаатай холбогдуулан хэд хэдэн асуудлууд хуульч, эрх зүйчдийн дунд практикт тулгарах болсон юм. Тодруулбал шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал дамжин өнгөрөх үе шат болгон зохицуулаагүй бөгөөд талууд болон шүүхийн өөрийн санаачилгаар л хурал зарлах боломжтой байдлаар

¹ Должингийн Баярсайхан, *Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, онол практикийн хэлэлцүүлэг /Илтгэлийн эмхэтгэл/* (Улаанбаатар: 2017)

зохицуулагджээ. Өнөөгийн шүүхийн ачаалалтай холбоотойгоор шүүгч хэргийн материалтай урьдчилан танилцаагүй тохиолдолд тус хэрэгт урьдчилсан хэлэлцүүлгийн хурлаар орохгүйгээр шууд гэм буруугийн хуралд шилжих боломжтой байдлаар зохицуулагдсан. Дийлэнхдээ шүүх өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хэлэлцүүлэхээр товлох боловч талууд бэлтгэлгүй оролцох нь элбэг байдаг байна. Энэ нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдээгүй, бэлтгэл муу хэлэлцэгдэх тохиолдолд эргээд гэм буруугийн шатнаас прокурорт буцах үр дагаврыг бий болгох болжээ. Хэдий прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хассан боловч прокурорт даалгах зохицуулалтын дор нэмэлт ажиллагаанд хэргийг буцааж буй шүүхийн практик байна. Гэм буруугийн шатнаас шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг рүү буцаж болохгүй талаар хуульд тусгасан бөгөөд шүүхээс хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт даалгаж буй нь нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчим хэрэгжихгүйд хүрч байна.

Шүүхийн хувьд өөрийн санаачилгаар шүүхийн хэлэлцүүлгийг зарлахад хэргийн материалтай урьдчилан танилцсан байдаг бөгөөд шүүхээс прокурорт тодорхой ажиллагаа хийлгэх, зарим нотлох баримтуудыг тодруулах зорилготойгоор хэлэлцүүлж, яллах чиг үүргийг шүүх хэрэгжүүлж эхэлдэг. Энэ шатанд талууд бэлтгэлтэй оролцож, эрх тэгш мэтгэлцэх бус шүүгч гэм бурууг хэлэлцэхэд бэлтгэхээр тодорхой чиглэл өгөх нь яллах шүүхийн хэв шинжийг харуулж байж болох юм. Эцэст нь энэ бүхний дараа хэргийн хувь заяаг шийдвэрлэх дотоод итгэл шүүгчид хэзээний бүрдэх бөгөөд гэм буруу хэлэлцэхэд тухайн анхны итгэл үнэмшлээр хэргийг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд практикт тулгамдаж буй асуудлыг тодруулж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үр нөлөөг сайжруулахад дэм болох үүднээс уг судалгааг хийсэн болно.

II. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үүсэл хөгжил

A. Гаднын улсад

Англи улсад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь 12-р зууны үеэс эхтэй бөгөөд энэ нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны нэг хэсэг болж хөгжсөн байна. Тухайлбал 1554 онд Парламент шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зарим элементүүдийг хуульчилж, шүүхийн шийдвэрийг нээлттэй хуралдаанд гаргах, нотлох баримтыг бичгээр бүртгэх шаардлагыг тогтоож байжээ. Энэ нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн эхлэл байв. Америкийн Нэгдсэн улсад /цаашид АНУ/ 1966 онд “Bail Reform Act” батлагдсанаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ач холбогдол нэмэгдэж, шүүхийн шийдвэрийг шударга,

тэгш байлгах зорилгоор шинэчлэлтүүд хийгдсэн байна².

Шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн хөгжлийн явцад XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед “хэдийгээр шүүх шударга байж болох ч түүнээс өмнөх шатанд гэмт хэргийг шалгаж, мөрдөн нотлох ажиллагаа нь нэг талыг барихгүй, эрүүдэн шүүлт тулгахгүй, зохиомол хилс хэрэг бүрдүүлж, нотлох баримтыг хуурмаглахгүй байх баталгаа, түүний шударга байдлыг хэрхэн хангах вэ” гэсэн асуудал тулгамдсан. Тухайн асуудлыг шийдвэрлэх мөн шударгаар шүүлгэх эрхийн шаардлагын үүднээс “due process” үүсэн бий болсон байна. “Due process” нь хуульд заасан журмаар ажиллагаа явуулаагүй, процессын явцад оролцогчдын эрхийг зөрчсөн бол тухайн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим юм. “Due process”-ийн зөвхөн нэг арга хэрэгсэл бол “шүүхийн өмнөх хэлэлцүүлэг” бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагаа шударга байх явдлыг хангах үүднээс эрүүгийн хэрэг үүсгэх, нотлох баримтыг үнэлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт процессын ажиллагааг алдаагүй явуулах төрөл бүрийн хэлэлцүүлгүүдээс / hearing/ бүрддэг³. Орчин үед “Due process”-ийг хангахыг олон улсын хүний эрхийн байгууллага шаардаж, дэмжиж ирсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын /цаашид НҮБ/ Хүний эрхийн хорооноос илтгэснээр “шүүх ажиллагааны шударга байдал нь шууд болон шууд бус байдлаар хөндлөнгөөс нөлөөлөөгүй байх, ямар нэгэн зорилгоор, аль нэг талаас нэхээгүй, шаардаагүй, дарамтлаагүй, саад болоогүй гэдгээр илэрхийлэгдэнэ” гэжээ⁴. Мөн шударга байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бол яллах, өмгөөлөх талын хооронд тэгш байдлыг хангах явдал гэсэн байна.

Англи, Америкийн эрх зүйд урьдчилсан хэлэлцүүлэг нь тухайн хэрэгт бичгээр нотлох баримт бүртгэх, шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах журмуудтай уялдсан. Европын бусад орнуудад (Германд, Францад) урьдчилсан хэлэлцүүлэг нь 18-19-р зууны реформын үеэр шүүхийн хяналтын механизмыг сайжруулах, прокурорын үүргийг тодорхойлох зорилгоор хөгжсөн. Англи-Америк улсын онцлогийн хувьд мэтгэлцэх зарчмыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа бүрэн баримталдаг бөгөөд өмгөөлөгч нь мөрдөгч,

² United States Courts, *Federal Probation*, https://www.uscourts.gov/sites/default/files/71_2_6_0.pdf?utm_source=common_law.pdf, <https://harvardlawreview.org/print/vol-137/bail-at-the-founding/>, https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein_Origins_of_Public_Prosecution_at_Common_Law.pdf?utm_source=chatgpt.com, (Сүүлд үзсэн: 2025.08.01).

³ Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлэг, Бодлого судалгааны тайлан”, 2020, 9 дэх тал, https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf, (Сүүлд үзсэн: 2024.03.01).

⁴ Хүний эрхийн хороо, 32-р ерөнхий зөвлөмж, 25-р догол мөр, дам эшлэв.

прокурорын нэгэн адил нотлох баримтыг цуглуулж бэхжүүлдэг юм. Энэ утгаараа мэтгэлцэх зарчмыг бүрэн утгаар хэрэгжүүлж, талуудын эрх тэгш байдлыг хангах зорилготой тус хэлэлцүүлэг нь манай улс шиг шүүхийн шатанд мэтгэлцэх зарчмыг баримталдаг холимог системд онцлогт нутагшуулж чадвал хүний эрхийг хангасан, ардчилсан улсын хэв шинжийг агуулсан сайшаалтай үр дүнг бий болгох юм.

Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль /2008/-д Монгол улс нэгдэж ороогүй ч гэсэн нийтлэг жишиг түгээмэл хандлагыг баримталбал зохих бөгөөд уг хууль 17 хэсэг, 346 зүйл, 420 тайлбартай. Тухайн хуулийн гол зорилго нь социалист тогтолцооны дараах болон шилжилтийн үеийг даван туулж буй улс, орнуудад эрүүгийн процессын хуулиа шинээр гаргах, шинэчлэн өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэхүйц үзэл баримтлал, суурь зарчмыг тодорхойлж, үлгэрчилсэн хуулийн хэв маяг, эх сурвалжийг гаргахад чиглэгдсэн. Тус загвар хуульд өндөр хөгжилтэй орон болон аль нэг систем, тогтолцооны шинжийг чухалчлан тусгаагүй, харин дундын буюу хосолсон зохицуулалт бүхий дэлхий нийтийн орчин үеийн түгээмэл хандлагыг тусгаснаараа ач холбогдолтой баримт бичиг болсон хэмээн судлаачид үздэг⁵. Эрүүгийн загвар хуулийн 3 дугаар хэсгийн 228-238 дугаар зүйлд, нотлох баримтын дүрэм, стандарт болон эрүүгийн хэргийн талаарх мэдээлэл, баримт сэлтийг нотлох баримтад тооцох шалгуур, нөхцөл журмыг тусган оруулжээ. Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөхүйц, эргэлзээгүй байдлыг хангах, шууд хамааралгүй буюу давхардсан эсвэл дамжмал хамаарал бүхий баримт сэлтүүдийг нотлох баримтаас хасах, харилцан яриаг нотлох баримтад тооцохгүй байх зэрэг нөхцөлүүдийг нарийвчлан зааж, тайлбартайгаар тодорхойлжээ. Шүүх дээр нэмэлт нотлох баримт гаргах нөхцөл боломжийг хуульчилж, яллах нотлох баримт бүхий хавтаст хэргийг шүүхэд шилжүүлэхийг хязгаарлаж, шүүхэд шилжүүлэхийн өмнөх шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал хийх, шүүх хуралдааныг шударгаар, эрх тэгш байдлыг хангаж явуулах зэрэг нийтлэг агуулгыг тусгасан бөгөөд мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр тогтоогоогүй баримтаар гэм буруутай гэж ял тулгаж харьцахгүй байх байна.⁶

Б. Монгол улсад

Монгол улсын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь цоо шинэ ойлголт биш бөгөөд 1940 оны Үндсэн хуулийн агуулга зарчимд нийцүүлэн 1949 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 4 дүгээр зарлигаар БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баталсан нь эх газрын буюу Ром, Германы эрх

⁵ Должингийн Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2015), 19 дэх тал.

⁶ Должингийн Баярсайхан, өмнөх эшлэл 5, 19-20 дахь тал

зүйн тогтолцоонд тулгуурласан бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа бүхэлдээ мөрдөн шүүдэг хэв маягтай байсан байна.

БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь 5 хэсэг, 26 бүлэг, 440 зүйлтэй, хуулийн 1-р хэсэгт хэргийн харьяалал, шүүх бүрэлдэхүүн болон хэргийн зохигчдын татгалзал, нотлох баримтуудын төрөл, ангилалт, протоколын тухай, байцаан шийтгэх ажиллагааны хугацаа, шүүхийн зардлын асуудал зэргийг тусгасан байдаг боловч энэ хууль нь тэр үеийн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хуулбарласан байв.

Монгол Улсад 1949 оныг хүртэл нийтдээ гурван ч удаа Эрүүгийн байцаан шийтгэх хууль батлагдан гарсан боловч хэрэгжилт нь хангалтгүй, эрүүдэн шүүлтийн хэв маягууд зонхилсон, төрийг төлөөлөн байцаан шийтгэх үйл ажиллагаа явуулж буй субъектүүдийн мэдлэг чадвар хомс, нам төрийн бодлогоос шууд хамааралтай, зарим тохиолдолд бүрэн эрхт комиссын шийдвэрээр үйл ажиллагаа явагдаж, прокурорын хяналтаас ангид, үүдэн «хэлмэгдүүлэлт» гэсэн хар сүүдрийг дайран өнгөрчээ⁷. Үүнээс дүгнэхэд 1935-1949 оны тухайд нийгэм эмх замбараагүй байхын зэрэгцээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хууль нь нам, төрийн бодлоготой холбоотойгоор хэрэгжиж, их хэлмэгдүүлэлтийн үеийг бий болгосон бөгөөд тус үед шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа байгаагүй болохыг илтгэж байна.

Тодруулбал тухайн цаг хугацаанд Порт-Артурын хэрэг гэж нэрлэгдэх Х.Чойбалсангийн амь насыг хороох гэсэн хэрэг 1948 онд гарсан хэмээн хилс хэрэг зохиож 100 гаруй хүнийг баривчлан 40 гаруйг нь буудан хөнөөв. Тэдний дотор Монголд амьдарч байсан Хятад иргэд цөөнгүй байсан аж. Энэ хэрэг Порт-Артурын хэрэг нэрээр түүхэнд тэмдэглэгдэн үлджээ⁸.

1930, 1960-д оны улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн ялыг тэдний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэж, тэдгээр хүмүүсийг эрхэлж байсан ажил, албанаас халах, сурах, эвлэлдэн нэгдэх, улсын байгууллагад ажиллах, сонгогдох эрхийг хязгаарлах, “эсэргүү нарынхан” гэсэн хэллэг, ялгаварлалыг нийгэм бараг хүлээн зөвшөөрөхөд хүртэл гүнзгийрүүлсэн байлаа⁹.

1949, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ажиллагаа нь “бэлтгэл цуглаан” гэсэн нэртэй байсан. 1949 оны Эрүүгийн

⁷ ХЗҮХ, ХЗДХЯ, *Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2011 он*, 2012.

⁸ Баабар, *Монголчуудын нүүдэл, суудал* (Улаанбаатар: Соёмбо принтинг, 2006), 495-497 дэх тал.

⁹ Нанзаддоржийн Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль Шинжлэх ухааны тайлбар*, (Анхны хэвлэл), (Улаанбаатар: Адмон, 2022), 289 дэх тал.

байцаан шийтгэх хууль (ЭБШХ гэх)-аар прокуророос ял төлөвлөж ирүүлсэн бүх хэргийг шүүхэд шилжүүлэх асуудлыг нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй бэлтгэл цуглаанаар хэлэлцдэг байсан бол 1963 оны ЭБШХ-аар ялын төлөвлөгөөний дүгнэлт болон гэмт хэрэгт оногдуулсан эрүүгийн хуулийн зүйл, ангийг зөвшөөрөхгүй, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх шаардлагатай байвал нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй захиран тушаах хурлаар хэлэлцэж, бусад тохиолдолд яллагдагчийг шүүгчийн тогтоолоор шүүхэд шилжүүлэхээр зааж байжээ. (ЭБШХ, 1963 он. III хэсэг, 24 дүгээр бүлэг 219-237 дугаар зүйл)¹⁰.

Бэлтгэл цуглаанаар дараах асуудлыг шийддэг байжээ. Үүнд:

- Шүүгч хэргийг ялын төлөвлөгөөний хамт прокуророос хүлээн авмагц “бэлтгэл цуглаан”-аар хянан хэлэлцүүлэхээр оруулах ёстой байсан бол яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг хэрэг хүлээн авснаас хойш шүүгчийн тогтоолоор 7 хоногийн дотор, захиран тушаах хурлаар 10 хоногийн дотор шийдвэрлэх (ЭБШХ, 1963 он. 219-221 дүгээр зүйл);

- “Бэлтгэл цуглаан”-д хэргийн талаар прокурор илтгэгчээр оролцох буюу мөрдөн байцаагчийг бэлтгэл цуглаанд оролцуулах бөгөөд илтгэгчээр томилон явуулах эрхтэй байсан бол захиран тушаах хуралд шүүгч ялын төлөвлөгөөний дүгнэлтүүд, хуулийн зүйл, анги, таслан сэргийлэх арга хэмжээг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлийн талаар илтгэж, мөн холбогдох байгууллага, хүмүүсийн гаргасан хүсэлт, прокурорын дүгнэлтийг сонсож зөвлөлдөх тасалгаанд магадлал гаргах журмаар шийдвэрлэх;

- Яллагдагч оргон зайлсан, оршин суугаа газар нь мэдэгдэхгүй байвал түүнийг олдох хүртэл, түүнчлэн яллагдагч сэтгэл мэдрэлийн буюу бусад хүнд өвчний улмаас шүүх хуралд оролцох бололцоогүй нь эмнэлгийн байгууллагад ажиллаж байгаа их эмчийн магадлаагаар нотлогдож байвал эдгэртэл нь шүүх хурлыг түдгэлзүүлэх, уг хэрэг өөр шүүхэд харьяалагдахаар байвал харьяаллын дагуу шилжүүлэх;

- Урьдчилсан мөрдөн байцаалт бүрэн биш бөгөөд тэр нь шүүх хурлаар нөхөн гүйцэтгэх бололцоогүй, хэрэг бүртгэх буюу урьдчилсан мөрдөн байцаалт явуулах үед эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, урьд сонгосон ял дээр нэмж ял сонгох, эсхүл ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаар нь ялын төлөвлөгөөнд дурдсанаас онцын ялгаатай болгон өөрчлөх үндэстэй, уг хэрэгт өөр хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах үндэстэй бөгөөд тэдний материалыг хэргээс тусгаарлах боломжгүй, хэргийг буруугаар

¹⁰ ХЗҮХ, ХЗДХЯ, өмнөх эшлэл 8.

тусгаарласан буюу нэгтгэсэн бол нэмж мөрдөн байцаалт явуулахаар хэргийг прокурорт буцаах;

- Хуульд заасан үндэслэл байвал хэргийг хэрэгсэхгүй болгохоор тус тус заажээ¹¹.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 226 дугаар зүйлд Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхэд шийдвэрлэвэл зохих асуудал нэрийн дараах байдлаар тусгажээ.

226.1. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ шүүгч дараах асуудлыг тодруулсан байна:

226.1.1. хэрэг уг шүүхэд харьяалагдах эсэх;

226.1.2 хэргийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэх;

226.1.3. яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох эсэх;

226.1.4. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүх хуралдааныг явуулж болохгүй байдалд хүргэх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн явдал байгаа эсэхийг тодруулсны үндсэн дээр хуралдааныг товолдог байжээ.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд /ЭХХШТХ/, шүүхийн гэм буруугийн хуралдаанаас прокурорт буцаах зохицуулалтыг хүчингүй болгож, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх /цаашид ШУХ/ зохицуулалтын ЭХХШТХ-д VII хэсэг 33 дугаар бүлэгт “Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа” нэршилтэйгээр оруулж ирсэн.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргахаар зохицуулсан байна. Тодруулбал:

- Өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;

- Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт;

- Эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол, нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;

- Прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;

- Яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;

- Шүүх хуралдааныг хялбаршуулж явуулах тухай хүсэлт;

¹¹ Нээлттэй нийгэм форум, өмнөх эшлэл 4, 14-р тал.

- Яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;
- Яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;
- Шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт;
- Шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал, хүсэлт;
- Шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;
- Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;
- Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;
- Мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;
- Хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;
- Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.

Мөн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт “ Урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6.13, 6.14, 6.15, 6.16-д заасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг гомдол, хүсэлтийг шийдвэрлэнэ.” гэсэн зохицуулалт үйлчилж байсан, тодруулбал тухайн тохиолдолд шүүх хуралдаанаас прокурорт хэргийг буцааж болохоор байжээ.

Дээрхээс үзвэл манай улсад 2017 онд Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалт цоо шинээр орж ирсэн бөгөөд гэм буруугийн шатнаас прокурорт хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаахаас урьдчилан сэргийлж, талуудыг идэвхжүүлэх, эрх тэгш мэтгэлцэх боломжоор хангах зөвхөн энэ шатанд цугларсан нотлох баримтын хүрээнд, гэм бурууг эцэслэн тогтоож шийдвэрлэх үзэл баримтлалтайгаар орж ирсэн зохицуулалт болно.

Энэ 2017 оны ЭХХШТХ-ийн өөрчлөлтөөрөө Монгол улс бол шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах /инквизици- Investigation process/, шүүхийн шатанд мэтгэлцэх /аккусац- Accusatory process/ буюу холимог буюу хосолсон /Equivocacy and mixed process/ хагас нээлттэй зарчмыг тунхагласан эрх зүйн орчин бүрдсэн байна¹². ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.15 дугаар зүйлд зааснаар нэмж, нэмэлт ажиллагаа хийлгэхээр, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шийдвэрлэх болсон нь гэм буруугийн хэлэлцүүлэгт прокурорт

¹² Монголын хуульчдын холбоо, Должингийн Баярсайхан, “Эрүүгийн процессын эрх зүйн зарим тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг, 2017.12.08, <https://www.youtube.com/watch?v=WUyGi8lSV9o&t=1966s>. (Сүүлд үзсэн: 2025.12.28).

буцаах үр дагавраас сэргийлэх зорилготой болно. Тодруулбал ЭХХШТХ-н 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй.” гэж заасан. Хэргийг буруу тусгаарласан, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн ба шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШТХ-г ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн алдаа гарсан тохиолдолд ЭХХШТХ-н 33.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 33.3 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд нэг удаа шүүгч хэргийг прокурорт буцаах боломжтой болсон.

“Шинэчилсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн чухамхүү нэг гол үзэл баримтлал нь шүүхийн хэлэлцүүлгийн үе шатыг хоёр хувааж шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, гэм буруугийн шүүх хуралдаан гэж зааглаж салгасан”

Заагласны мөн чанар, зорилго, агуулга нь Эрүүгийн процессын үндсэн «оролцогчид» болох мөрдөгч, прокурор, шүүгч нарт яллах ба цагаатгах нотлох баримтыг бүгдийг тэгш цуглуулах, үнэлэх, аль нэг талыг хэт баримталж, давуу байдлыг олгохгүйгээр шүүх хуралдаанд талууд мэтгэлцэхийг ЭХХША-ны суурь зарчим болгож хуульчилсан. Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд үндэслэсэн ЭХХШТХ-н зарчмуудыг бүхэлд нь дүгнэвэл “Нотол. Нотолж чадахгүй бол цагаатга” гэх зарчмыг манай улс үндэсний хууль тогтоомждоо нутагшуулсаар ирсэн байна. Үүнийг “Нэг гэмгүй хүнийг хилсээр ялласанд орвол зуун гэмт хэрэгтнийг сулла” гэдэг хэлц үгээр ч илэрхийлсэн нь байдаг.

Дээрхээс үзвэл өмгөөлөгчийн явуулах үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, оролцоог өргөжүүлэхээр шинэчлэлтэд тусгасан. Тухайлбал, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх тухай хүсэлт зэрэг 17 үндэслэлээр хэлэлцэж, урьдчилсан хэлэлцүүлгээс хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаах шийдвэр гаргуулж болохоор заасан. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед өмгөөлөгчөөс гаргасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх санал, хүсэлтийг шүүх хангахаар тусгасан.

Ш. Практикт тулгамдаж буй асуудал

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн механизмыг бүрэн ажиллуулахад дараах саад бэрхшээл тулгарч байна. Үүнд:

- Өмгөөлөгч хүрэлцэн ирдэггүй. /ЭХХШмХ, 33.1-8/

Өмгөөлөгч шүүх хуралдаанд идэвхгүй байр суурьтай оролцдог. Тодруулбал “Өмгөөлөгч оролцохгүй байх нь ШУХ явуулахгүй байх үндэслэл болохгүй гэж зохицуулсан.” *Нийт хэргийн бараг 60 орчим хувь нь өмгөөлөгчгүй буюу ЭХХШмХ-н 5.3 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр ЭХХША-г явуулж байна*¹³

- Өмгөөлөгч хүрэлцэн ирсэн боловч, чухал хэлэлцэгдэх нотлогдоогүй, нотлох баримтын зөрүү, нотлох баримтын харьцуулан шалгах ажиллагааг бэлтгэлгүй хийсвэр ярьдаг.

“*Хавтаст хэрэгт огт дурдагдаагүй хүнээс гэрчийн мэдүүлэг авах шаардлагатай байсан*” ямар үндэслэлээр, хэний мэдүүлэгт гарснаар, юуг нотлоход чухал ач холбогдолтой гэж үзэж байгаагаа хэлдэггүй. Тодруулбал нотолбол зохих байдлын хүрээнд нотлогдоогүй зарим байдал, нотлох баримтын ноцтой зөрүүтэй байдлыг, холбогдох нотлох баримтыг харьцуулах, шалгах ажиллагаа огт хийгдэхгүй зөвхөн хийсвэр байдлаар ярих, тайлбарлах нь хангалтгүй байдаг¹⁴.

2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тохиолдолд зайлшгүй өмгөөлөгч авах зохицуулалт орсон нь цаашдаа өмгөөлөгчийн байр суурийг өргөжүүлэх чиглэлд хөгжиж байна гэж үзсэн боловч 2025 оны байдлаар хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боловч шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлэгт өмгөөлөгч хүрэлцэн ирэхгүй байсан ч шүүгдэгчийн хүсэлтээр шүүх хуралдаанд өөрөө, өөрийгөө өмгөөлж оролцох тохиолдол их гарах болсон¹⁵.

- Шүүх өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг товлож болохоор зохицуулсан /ЭХХШтХ 33.1-6 /

Өнөөгийн практикт урьдчилсан хэлэлцүүлгээр мөрдөн шалгах болон нотлох баримт цуглуулж, бүрдүүлсэн ажиллагааг түүнчлэн прокурорын хяналтыг бүхэлд нь шүүхээр шалгах агуулгаар гэм буруугийн шийдвэр гаргах эрхтэй шүүгчид урьдчилсан хэлэлцүүлгийг удирдаж, хэргийн материалтай урьдчилан танилцах бололцоо олгосноор шүүгчид гарцаагүй урьдчилан дүгнэлт хийх, бүхнийг “төгс мэдэх” нөхцөлийг бүрдүүлж, талуудыг мэтгэлцээний

¹³ Нээлттэй нийгэм форум, *өмнөх эшлэл 4*, 35-р тал.

¹⁴ Шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлэгт сууж ажиглалт хийсэн, хуульчадаас асуулгын аргаар судалсан.

¹⁵ Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн практикаас, (Улаанбаатар: 2025).

үр дүнд бус урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнд дотоод итгэл үнэмшил бүрдэх нөхцөлийг бий болгожээ¹⁶. Өмгөөлөгч идэвх сул оролцох нь шүүх прокурорын ажлыг хянах чиг үүрэгтэй оролцох бөгөөд тэр нотлох баримт дутуу, энэ хэргийг нотлох энэ баримт нотлох баримтын шаардлага хангаагүй зэрэг шүүх яллах чиг үүргийг хэрэгжүүлж, мэтгэлцэх зарчим зөрчигдөх болсон. Эргээд тус хэргийг шийдвэрлэхэд шүүгчийн хүссэн нотлох баримтыг прокурор бүрэн гүйцэтгэлтэй хангаж орж ирснээрээ шүүх, прокурор гэх тус тус чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага нэг чиг үүргийг хэрэгжүүлж буй оршин буй илрэл болж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал хийхээр хуульчлаагүй. /ЭХХШтХ 33.1-4/

Тусгайлсан энэ үе шатыг шинээр оруулж ирээд, энэ үе шатанд л гэм буруугийн шатанд хэлэлцэгдэх хэргийн нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоосон эсэхийг хэлэлцэх үзэл санаагаар хуульчлагдсан боловч заавал хэлэлцүүлэг хийхээр зохицуулаагүй нь анхаарах асуудал юм. Монгол улсын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үндсэн хоёр хуваах бөгөөд шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах зарчим үйлчилж, шүүхийн шатанд мэтгэлцэх зарчим үйлчилдэг онцлогтой. Шүүхийн өмнөх шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар мөрдөгч, прокурор нотлох баримтыг бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй. Харин шүүхийн хэлэлцүүлгийн шатанд мөн хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар талуудын мэтгэлцээний үндсэн дээр шүүх шийдвэр гаргана. Тодруулбал мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч, прокурор онцгой эрхтэй буюу хэрэгжүүлэгчийн байр суурьтайгаар оролцдог бол өмгөөлөгч нь оролцогчийн байр суурьтайгаар нотлох баримтыг хэрэгт хавсаргах хүсэлт гаргадаг эрхээр хязгаарлагддаг. Харин яллагдагчийн цагаатгах талын нотлох баримтыг хэрэгт цуглуулж бэхжүүлэх хүсэлтийг өмгөөлөгч тавьж болох хэдий ч тус хүсэлтийг хүлээж авах эсэх нь мөрдөгч, прокурорын шийдвэр байдаг. Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад илт тэнцвэргүй байдал үүсдэг. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд гэм бурууг хэлэлцэхгүй байхаар хуульчилсан бөгөөд талуудын эрх тэгш байдлыг хангах зорилготойгоор нэг талаараа өмгөөлөгчид боломж олгосон, тэнцвэржүүлэхэд чиглэгдсэн зохицуулалт болно. Энэ шатанд л мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтууд хуульд заасан шаардлага үндэслэлийн дагуу цугларсан эсэх, хүний эрхийг зөрчсөн эсэх, яллагдагчийг цагаатгах талын нотлох

¹⁶ Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, “Шүүхээс хэргийг буцаах нь зайлшгүй асуудал уу?, эрдэм шинжилгээний өгүүлэл”, Эрх зүй, 51 (3), 2020, 373 дахь тал.

баримтуудыг дэлгэж талуудын эрх тэгш байдлыг тэнцвэржүүлэх үе юм. Гэтэл талууд бэлтгэлгүй, хайнга хандах нь энэ боломжийг алдахад хүргэж байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдээгүйн нэг үр дүнд прокурорт буцаах явдал юм. Хууль тогтоогч хэдий прокурорт буцаах зохицуулалтыг хүчингүй болгосон боловч прокурорт даалгах зохицуулалтын нэрийн дор практикт оршсоор байна. Тодруулбал зарим анхан шатны эрүүгийн шүүхийн хувьд ял завшуулахгүй байх үүднээс хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж, зарим нь хэргийг цагаатгаж шийдвэрлэх бөгөөд цагаатгасан хэргийн тухайд дээд шатны шүүхээс хэргийг хүчингүй болгож¹⁷ дахин хэлэлцүүлэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь цаг хугацааны хувьд болоод шүүгдэгчийн хувьд эрүүдэн шүүлт болж хохирогчийн хувьд сэтгэл санааны дарамтад байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол улс Ардчилсан улсын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн чиг үүргийг харилцан хяналт, тэнцвэр бүхий талуудад хариуцуулах, хооронд нь санал бодлоо уралдуулан мэтгэлцүүлэх, хөндлөнгийн байлгах явдлыг гол үндэс болгохыг зорьж байгаа болно. Гэвч прокурорт шүүхийн санаачилгаар хэргийг буцаах болон дээд шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаах нь дээрх чиг үүргийн тэнцвэртэй хуваарилалтыг зөрчдөг. Тодруулбал шүүх хөндлөнгийн шинжтэй байж, нотол, нотолж чадахгүй бол цагаатга буюу нотлогдоогүй бол гэм буруугүйн зарчим эсхүл яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим хэрэгжихгүйд хүрч, яллах шүүхийн шинжийг харуулж байна¹⁸. Нөгөө талаар мөрдөгч, прокурор нь хаашдаа шүүхээс буцаадаг заалт байгаа юм чинь гэдгээр дутуу шалгасан, хэргийн бодит байдал бүх талын нотлох баримтаар нотлогдож чадаагүй, “дутуу боосон” хэргийг шүүхээс чиглэл авчихъя гэдэг байдлаар шүүхэд шилжүүлж, улмаар тодорхой чиглэл авч буцаалган тэр чиглэлийнхээ хүрээнд дахин ажиллагаа хийдэг хариуцлагагүй байдал үүснэ. Нүдээ боосон охин тэнгэрээс нүдний шилтэй Зевс бурхан¹⁹ Хуралдааны явцад шүүхийн санаачилгаар бодит байдлыг тогтоох зорилгоор хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд буцаавал мэтгэлцээнээр тогтоох ойлголттой зөрчилд хүрэх нь зайлшгүй юм. Иймд өмгөөлөгч, мөрдөгч, прокурорыг хариуцлагажуулах үүднээс зайлшгүй дамжин өнгөрөх нэг үе шат болгон хуульчлах шаардлага байна.

- Зарим зохицуулалтыг давхардуулсан /ЭХХШТХ 34.16-6/

¹⁷ Улсын Дээд шүүхийн шүүгч Батаагийн Батцэрэн, “Хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх үндэслэл болохгүй”, 2023, <https://legaldata.mn/shiidver/huraangui/view/174>, (Сүүлд үзсэн: 2026.01.10).

¹⁸ Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, *өмнөх эшлэл 17*, 357-358 дугаар тал.

¹⁹ Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, *өмнөх эшлэл 17*, 368 дугаар тал.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд 15 үндэслэлээр бэлтгэл хангах ажиллагаа хийлгэх эрх нээлттэй байдлаар зохицуулсан. Эдгээр хуульд заасан ажиллагаа хийлгэх үндэслэлд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол гэж тусгасан бөгөөд шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлэгт мөн дээрх үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах буюу прокурорт даалгаж болох талаар дахин зохицуулсан нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хүчийг сулруулж байна. Өмгөөлөгч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт идэвхгүй оролцож, эргээд хуралдааныг хойшлуулах боломжтой гэх харин прокурор алдаа байвал шүүх хянадаг гэж ажилдаа хайнга хандах өнцгийг бий болгож байна.

Баянзүрх дүүргийн прокурорын газраас, шүүхээс прокурорт хэргийг буцаасан шалтгаан нөхцөлийг 2022 оны 4 дүгээр улирлын судалгаа хийгдсэн байна. /2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд/²⁰ Судалгаа хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдсон байна. Үүнд:

Дээрх хугацаанд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн хэргээс анхан шатны шүүхээр 894 хэрэг, давж заалдах шатны шүүхээр 94 хэрэг, хяналтын шатны шүүхээр 5 хэрэг, нийт 993 хэрэг шүүхээр хянан хэлэлцэгдсэн ба судалгаанд хамрагдах хугацаанд нийт 33 хэрэг буюу 4 хувь нь прокурорт буцаж шийдвэрлэгдсэн байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх болсон үндэслэлээр авч үзвэл, шүүхийн санаачилгаар 9, яллагдагч болон яллагдагчийн өмгөөлөгчийн хүсэлтээр 17, хохирогчийн төлөөлөгчийн гаргасан хүсэлтээр 1 хэрэг байна. ШУХ-н ололттой ба дутагдалтай талууд юунд байгааг олж тогтоон цаашид энэ талаар авах арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлох зорилгоор ярилцлагын судалгааг явуулсан байна²¹. Судалгаанд оролцогчдын 49 хувь нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцээний хэлбэрийг ягштал баримтлах явдал хэвшил болон төлөвшиж чадсан. Мэтгэлцээний хэрэгжилт бүрэн бус байна гэж, судалгаанд оролцсон прокуроруудын 50 хувь, харин өмгөөлөгчдийн 50.6 хувь нь дүгнэсэн байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хэлэлцэгдсэн асуудлаар нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг прокурорт буцаасан боловч, гүйцэтгэхгүйгээр эсхүл бүрэн бус дугуу гэм буруугийн хэлэлцүүлгийн шатанд орж ирсэн тул дахин 60 хоногийн зохицуулалтаар давтан даалгах үр дагаварт хүргэсэн байна. Тодруулбал БЗД-н Прокурорын газрын 4-р улирлын, шүүхээс

²⁰ Баянзүрх дүүргийн прокурорын газарт, улирал бүр тогтмол судалгаа шинжилгээ хийгдэж, үр дүнд үндэслэн мэргэжлийн арга зүйн зөвлөгөөг хүргэдэг байна.

²¹ Нээлттэй нийгэм форум, *Өмнөх эшлэл 4*, 35-р тал.

прокурорт хэрэг буцах судалгаанаас үзэхэд захирамжид заасан ажлыг дутуу гүйцэтгэсэн үндэслэлээр, шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлгээс буцсан хэргийг тусгайлан нэг үндэслэл болгон судалгаа хийгдсэн байна.

Дээрхээс дүгнэвэл Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс прокурорт буцсан нийт 14 хэргээс 10 нь ЭХХШТХ-ийн 16.2 дугаар зүйлд заасан “Нотолбол зохих байдал” бүрэн хангагдаагүйтэй холбоотойгоор прокурорт буцсан бол “Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчсөн” үндэслэлээр 1 хэрэгт, “Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн” үндэслэлээр 2 хэрэгт, “Зүйлчлэлийг өөрчлөх” үндэслэлээр 1 хэрэгт прокурорт буцааж шийдвэрлэсэн байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хийх санаачилгаар хоёр дахь байрыг шүүх эзлэх бөгөөд шүүх өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зарлах нь яллах шүүхийн хэв шинжийг агуулж байна гэж үзэх үндэслэлтэй. Нотлох баримтын бүрдэл дутууг гүйцээх тухайд шүүхээс чиглэл өгч гэм буруугийн хэлэлцүүлэгт прокурорт шүүгчийн зааврыг гүйцэтгэж орж ирснээрээ бие биеэсээ үл хамааралтай байх бүтэц зөрчигдөж, шүүх яллах нь гарцаагүй зүйл болсон юм. Тухайн зохицуулалтыг давхардуулж хууль тогтоомжид тусгагдсан тухайд прокурорт даалгаж шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалтыг урдаа барьж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдээгүй тул энэхүү боломжоор хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж байна.

IV. Гадаад орнуудын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ижил болон ялгаатай байдал

Дэлхийн орнуудын эрх зүйн тогтолцоо нь тухайн улсын үндэсний ёс заншил, соёл, нийгмийн харилцааны хөгжил, онцлогийг тусгахаас гадна олон улсын эрх зүйн системийн хэв маяг, нийтлэг жишиг, чиг хандлагыг харгалзан хөгжсөн байдаг²². Харьцуулсан эрх зүйн судлалыг үндэслэгчдийн нэг Францын судлаач А.Леви-Ульманы ангиллаар дараах байдлаар ангилсан байна. Үүнд:²³

Англи-Америкийн, /Англи, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд, /

Эх газрын, /Итали, Португал, Франц, Герман, Грек, Турк/

Мусульманы, /Иран, Саудын Араб, Афганистан, Ирак, Катар/

²² Должингийн Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, онол практикийн хэлэлцүүлэг, /Илтгэлийн эмхэтгэл, “Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага”.

²³ Должингийн Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (2 дахь хэвлэл) (Улаанбаатар: Соёмбо, 2012), 40 дэх тал.

Хосолсон ба холимог эрүүгийн, /БНХАУ, Япон, Филиппин, ОХУ/ гэх мэт. Иймд дээрх ангиллын хүрээнд тогтолцоо бүрийн харилцан онцлогийг харгалзаж дараах улсуудыг сонгож харьцууллаа.

А. Бүгд Найрамдах Солонгос Улс²⁴

Бүгд Найрамдах Солонгос улсын хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн процессын хуулийн 266.5 дугаар зүйлд “Шүүх хуралдааны өмнөх бэлтгэл ажиллагаа” нэршилтэйгээр ШУХ хуульчлагджээ. Үүнд:

Эрүүгийн процессын хуулийн 266.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлгийг заавал дамжин өнгөрөх нэг үе шат болгоогүй байна. Мөн хуулийн 2 дахь заалтад зааснаар шүүх талуудын санал, хүсэлтээр болон өөрийн санаачилгаар манай улсын адил хэлэлцүүлгийг хэлэлцэх боломжтой. Ингэж хэлэлцүүлэхдээ 266.3 дахь заалтад зааснаар талуудаас гарсан хүсэлт, гомдлыг нөгөө талд гардуулж тодорхой хугацаа заалгүйгээр мэтгэлцэх боломж, бэлтгэхэд хангалттай боломжоор хангадаг байна.

Мөн хуулийн 266.4 дэх заалтад зааснаар шүүх өөрийн санаачилгаар хэлэлцүүлж байгаа тохиолдолд хэрэгт хэлэлцэх шаардлагатай баримтуудыг шаардаж, шүүгчийн захирамжаар ажиллагаа хийлгэх талаар дурдаж прокурорт буцаах боломжтой байдлаар зохицуулжээ. Энэ нь манай улсын зохицуулалтай ихээхэн төстэй байдлаар зохицуулагджээ. Гэвч 266.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хэлэлцүүлгийг хэд хоногийн өмнө товлох тухай өдрийг тодорхой заагаагүй ч талуудыг харгалзаж огноог товлохоор тусгасан байна. Манай улсад уг хэлэлцүүлэг хэлэлцүүлэхээс 3 хоногийн өмнө товлох талаар нарийвчлан зохицуулсан улс байдаг боловч шүүхийн ачаалалтай холбоотойгоор уг хугацаа алдагдаж гэнэтийн байдлаар зарлагдаж, бэлтгэлгүй ордог нөхцөл байдал практикт ажиглагддаг. Тодорхой хугацаа зааж өгөөгүй нь өөрөө тус хэлэлцүүлэгт талуудын мэтгэлцээнд бэлтгэх боломжийг олгож байна гэж харах боломжтой.

Мөн хуулийн 266.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тус хэлэлцүүлгийг удирдаж, талуудын мэтгэлцээнийг буюу мөрдөн шалгах ажиллагааны явцтай холбоотой асуудлуудыг гэм бурууг хэлэлцүүлэхээс өөр шүүгч шүүх бөгөөд тус шүүгч нь даргалагч шүүгчийн нэгэн адил эрх мэдэлтэй байхаар зохицуулсан байна. Тодруулбал гэм бурууг шийдвэрлэх шүүгч, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг өөрийн санаачилгаар хэлэлцүүлэх нь тус хэргийг төгс мэдэх хэв шинжтэй болж, яллах шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлж эхэлдэг бөгөөд үүнийг тусдаа бие даасан шүүхийн шүүгчээр

²⁴ Бүгд Найрамдах Солонгос улсын Эрүүгийн процессын хууль, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535, (Сүүлд үзсэн: 2025.11.22)

шийдвэрлүүлэх нь шүүгчийн тус хэргийн хувь заяаг шийдвэрлэх дотоод итгэл үнэмшил бэлтгэх үед бүрдэхээс сэргийлэх онцлогтой.

266.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хэлэлцүүлэгт зайлшгүй өмгөөлөгч оролцуулах шаардлагатай талаар зохицуулсан. 268.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт яллагдагч өмгөөлөгч аваагүй байх тохиолдолд улсаас өмгөөлөгч томилон оролцуулах асуудлыг шүүх шийдвэрлэхээр тусгаж өгсөн бөгөөд тус хэлэлцүүлэг эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдах болохыг илтгэж байна. 266.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тус хэлэлцүүлгийн шийдвэрт талууд гомдол гаргах боломжтой бөгөөд нарийн бичгийн дарга тухайн шүүхийн хэлэлцүүлгийн процессыг тэмдэглэж, тэмдэглэл гаргадаг байна.

266.11 дүгээр зүйлд зааснаар өмгөөлөгч шинээр нотлох баримт гаргаж өгөх болон нотлох баримтыг хэргээс хуулбарлаж авч болохоор зохицуулсан. Харин хуулбарласан нотлох баримтыг гадагш задруулбал хуульд заасан хариуцлага хүлээдэг байна. 266.14 дүгээр зүйлд гэм бурууг хэлэлцүүлэх шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү шилжүүлэх боломжтой гэж зохицуулсан байна. Манай улсад анх Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтыг оруулж ирэхдээ 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт шүүхийн гэм буруугийн шатнаас эргээд урьдчилсан хэлэлцүүлэг рүү шилжүүлж болно гэж хуульчилсан бөгөөд үүнийг хүчингүй болгосон байдаг.

*Б. Болгар улс*²⁵

Болгар улсын Эрүүгийн процессын хуулийн 247а зохицуулалтад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг сонсгол гэж нэрлэсэн. Уг сонсголыг хэргийг хүлээж авснаас хойш 2 сарын дотор товлох бөгөөд хэрэг ээдрээ төвөгтэй бол 3 сарын хугацаанд товлон зарлахаар хуульд тусгалаа олжээ. Мөн хуулийн 247б-2 дахь хэсэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт яллагдагчийг өмгөөлөгчтэй оролцох эрхээр хангах бөгөөд өмгөөлөгчтэй оролцох хүсэлттэй байгаа тохиолдолд өөрийн өмгөөлөгчийг оролцуулах эсхүл томилолтын өмгөөлөгч оролцуулах боломжоор хангадаг байна. 247с-3 дахь заалтад өмгөөлөгч зайлшгүй оролцуулах шаардлагатай хэргүүд нь ээдрээ төвөгтэй болон хуульд заасан заавал өмгөөлөгч оролцуулах шаардлагатай хэргүүдэд өмгөөлөгч оролцуулах боломжоор хангана гэж зохицуулжээ. Тус сонсголоор 248 дугаар зүйлд зааснаар 9 асуудлыг хэлэлцүүлэхээр зохицуулсан байна. Болгар улсын хувьд сонсгол ажиллагаа хийгддэг. Энэхүү ажиллагаа нь бүх хэрэгт хийгдэх бөгөөд тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас хамааран хугацааг тогтоож өгдөг. Манай улсаас ялгаатай зүйл нь бүх хэрэгт сонсгол ажиллагаа хийгддэг бол

²⁵ Болгар улсын Эрүүгийн процессын хууль, [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2019\)034-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2019)034-e), (Сүүлд үзсэн: 2025.11.22).

харин өмгөөлөгч зайлшгүй хэлэлцүүлэгт оролцох шаардлагагүй буюу яллагдагчийн хүсэлтээс хамааран өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй болох нь сонсголыг зогсоох үндэслэл болдоггүй байна.

248 дугаар зүйл

1. Үйл ажиллагааны сонсголоор дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- хэрэг шүүхийн харьяалалд хамаарах эсэх;
- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэх;
 - шүүхийн өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрмийг ноцтой зөрчсөн, яллагдагч, хохирогч болон түүний өв залгамжлагчийн журмын эрхийг хязгаарлахад хүргэсэн эсэх;
 - хэргийг тусгай дүрмийн дагуу хянан үзэх үндэслэл байгаа эсэх;
 - хэргийг хаалттай хаалганы цаана хянан үзэх, нөөц шүүгч буюу шүүгчийг оролцуулах, сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст өмгөөлөгч, шинжээч, орчуулагч эсвэл тусгай туслах томилох, шүүхийн хуралдааныг шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх тухай;
 - хяналтын арга хэмжээ;
 - шинэ нотлох баримт цуглуулах хүсэлт;
 - шүүх хуралдааны хуваарь болон түүнд дуудагдах хүмүүсийн талаар.
 - Шүүх нь шүүх хуралдаанд оролцогч талуудаар оролцох хүсэлтийн талаар мэдэгдэл гаргана зэрэг үндсэн 9 асуудлаарх тус хэлэлцүүлгийг явуулахаар хуульчилжээ.

*В. Эстони улс*²⁶

Эстони улсын Эрүүгийн процессын хуульд ШУХ-ыг шүүхийн урьдчилсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж нэрлэх бөгөөд тус чиг үүргийг шүүгч дангаар хэлэлцэж, гарсан захирамжид гомдол гаргах эрхгүй байдлаар зохицуулжээ.

Мөн хуулийн 49 дүгээр зүйлд шүүхийн урьдчилсан мөрдөн байцаалтад оролцсон шүүгч гэм бурууг хэлэлцэхэд оролцох эрхгүй бөгөөд оролцох гэж буй тохиолдолд өөрөөсөө татгалзах эрх эдлэхээр заажээ. Шүүхийн урьдчилсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусдаа бие даасан шүүгч эрхлэн явуулахаар зохицуулсан байна.

²⁶ Эстони улсын Эрүүгийн процессын хууль, https://bwcimplementation.org/sites/default/files/resource/EE_Code%20of%20Criminal%20Procedure_EN.pdf. (Сүүлд үзсэн: 2025.11.20).

134.2 дугаар зүйлд зааснаар яллагдагчийг яллагдагчаар цагдан хорих саналыг прокурор, мөн урьдчилсан мөрдөн байцаалтын шүүгч авч болохоор заасан байна. Тус мөрдөн байцаалтын гэж нэрлэгдэх шүүгч өөрийн чиг үүргийг гүйцэтгэхдээ давхар цагдан хориог шийдвэрлэх бөгөөд тус гэм буруугийн хэлэлцүүлгийн шатнаас тусдаа бие даасан хараат бусаар шийдвэрлэж, шүүхийн урьдчилсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах боломжтой байдлаар зохицуулжээ. 2

59.2 дугаар зүйлд өмгөөлөгч зайлшгүй оролцохоор зохицуулсан бөгөөд өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүй хүрэлцэн ирээгүй бол өмгөөлөгчдийн холбоонд хариуцлага тооцуулахаар албан бичиг илгээдэг байна. 265.1 дүгээр зүйлд зааснаар уг хэрэгт шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон бүх хүмүүс урьдчилсан хэлэлцүүлэгт товлосон цагт шүүхэд ирэх боломжтой бөгөөд энэ нь шүүх хуралдааныг тасалдалгүй, хурдан явуулахыг хангах бөгөөд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд болон шүүх үүнтэй санал нийлсэн тохиолдолд үргэлжлээд гэм бурууг хэлэлцүүлэх боломжтой байдлаар зохицуулжээ.

*Г. Бүгд Найрамдах Хятад Ард улс*²⁷

187 дугаар зүйл.

- Хэргийг хэлэлцэх шүүх хуралдаан хийхээр шийдсэний дараа ардын шүүх шүүх бүрэлдэхүүний бүрэлдэхүүнийг тогтоож, шүүх хуралдаан эхлэхээс арав хоногийн өмнө ардын прокурорын яллах дүгнэлтийн хуулбарыг шүүгдэгч болон түүний өмгөөлөгчид хүргүүлнэ.

- Шүүх хуралдаан эхлэхээс өмнө шүүгчид улсын яллагч, талууд, өмгөөлөгчид болон шүүхийн төлөөлөгчдийг дуудаж, шүүх хуралдаантай холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулж, санал бодлыг сонсож болно, тухайлбал, шүүгчийг хасах, шүүхэд мэдүүлэг өгөх гэрчийн жагсаалт гаргах, хууль бусаар олж авсан нотлох баримтыг хасах зэрэг гэж зохицуулжээ. Тус улсын хуульд хаалттай байдлаар хэлэлцэгдэх асуудлыг зохицуулсан. Ингэхдээ тусгайлсан нэршил өгч тус ажиллагааг зохицуулаагүй бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд талуудын саналыг сонсохоор шүүх хуралдаан хийх боломжтой байдлаар зохицуулжээ.

- Шүүх хуралдааны нээлтийн огноог тогтоосны дараа ардын шүүх шүүхийн прокурорт шүүх хуралдааны нээлтийн цаг, байршлын талаар мэдэгдэж, талуудыг дуудаж, өмгөөлөгч, шүүхийн төлөөлөгч,

²⁷ Бүгд Найрамдах Хятад улсын Эрүүгийн Процессын хууль, https://www.chinalawtranslate.com/en/criminal-procedure-law-2018/#_Toc528744293, (Сүүлд үзсэн: 2025.10.20).

гэрч, таних тэмдэг, үнэлгээний мэргэжилтэн, орчуулагч нарт мэдэгдэж, шүүх хуралдаан эхлэхээс гурван хоногийн өмнө зарлан дуудах хуудас, мэдэгдлийг хүргүүлнэ. Хэрэв хэргийг нээлттэй хэлэлцэх бол шүүх хуралдаан эхлэхээс гурван хоногийн өмнө нэхэмжлэлийн үндэслэл, хариуцагчийн нэр, шүүх хуралдааны эхлэх цаг, газрыг зарлана. Дээрх үйл явцыг тэмдэглэлд тэмдэглэж, шүүгч болон шүүхийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурна гэжээ. Тухайн улсын хуульд өөр бэлтгэл хангах ажиллагаа, ШУХ-тэй холбоотой зохицуулалт байхгүй бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүхээс талуудыг дуудаж санал, хүсэлтийг сонсдог байна.

*Д. Япон*²⁸

Япон улсын Эрүүгийн процессын хуульд ШУХ-ийн хэлэлцүүлгийг шүүхийн өмнөх хэлэлцээр гэж нэрлэсэн бөгөөд үүнд прокурор болон яллагдагчийн өмгөөлөгч зайлшгүй оролцоно. Хэн хэн нь ирээгүйн хувьд шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно. Өмгөөлөгч байхгүйн хувьд шүүхээс өмгөөлөгч томилохоор зохицуулжээ. Тус хэлэлцүүлгээр шүүх хурлын үйл явцтай холбоотой бусад шаардлагатай асуудлаар шийдвэр гаргах зэрэг 11 үндэслэлээр хэлэлцэх боломжтой байдлаар зохицуулсан. 316.11 дүгээр зүйлд шүүхийн өмнөх хэлэлцээрийг шүүх шүүгч нь коллежийн шүүгч байж болох бөгөөд тус шүүгч нь гэм буруугийн хэлэлцүүлгийг шүүхгүй тусдаа бөгөөд шүүгчийн адил эрх мэдэлтэй байхаар зохицуулсан байна. Манай улсаас ялгаатайн хувьд тусдаа шүүгч шүүхийн өмнөх хэлэлцээрийг удирддаг байна. 316.13-1-р зүйл энэ шатанд гэм буруугийн асуудлыг огт хэлэлцэхгүй байдлаар зохицуулсан. 316.14 дүгээр зүйлд зааснаар гэм буруутайд тооцох нотлох баримтуудыг ангилан яллагдагчийн өмгөөлөгчид танилцуулж, өмгөөлөгчөөс тус нотлох баримтуудад дүгнэлт хийж, мэтгэлцэх боломжтой байдлаар хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх юм. Шүүх урьдчилсан хэлэлцээрийг дуусгахдаа улсын яллагч болон яллагдагч эсвэл түүний өмгөөлөгчтэй хэргийн асуудал, нотлох баримтыг зохицуулах үр дүнг баталгаажуулна гэжээ. Тус нотлох баримттай холбоотой шийдвэрт хүрсэн санал бодлоо илэрхийлсний дараа үр дүнд хүрсэн баримтуудаа баталгаажуулж тус хэлэлцүүлэг дуусдаг байна. Энэ улсын онцлогийн тухайд харьцангуй бусад улсыг бодоход талуудын идэвхтэй буюу пассив байдлыг шаардсан, хэргийг шүүх хурдан шийдвэрлэхэд талуудын оролцоо чухал болохыг тэмдэглэж, туслалцаа үзүүлэхээр хуульчилсан байна.

Мөн хуулийн 316.5-р зүйл. Шүүхийн өмнөх хэлэлцээрийн явцад дараах арга хэмжээг авч болно.

²⁸ Япон улсын Эрүүгийн процессын хууль, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2056/en>.

- Тооллого буюу холбогдох эрүүгийн хуулийг тодруулах
- Тооллого буюу холбогдох эрүүгийн хуулийг нэмэх, хүчингүй болгох, өөрчлөх зөвшөөрөл
- Шүүх хуралдааны өдөр гаргахаар төлөвлөж буй мэдэгдлийг ил болгосноор хэргийн асуудлыг зохицуулах
- Нотлох баримтыг шалгах хүсэлт гаргах
- Өмнөх зүйлийн заалтын дагуу нотлох баримт, шалгах асуудлууд болон хүссэн нотлох баримттай холбоотой бусад асуудлыг ил болгох
- Нотлох баримтыг шалгах хүсэлтийн талаарх санал бодлыг баталгаажуулах (үүнд 326 дугаар зүйлд заасан баримтат нотлох баримтад зөвшөөрөл өгөх эсэх)
- Нотлох баримтыг шалгах эсвэл нотлох баримтыг шалгах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах
- Шалгах шийдвэр гаргасан нотлох баримтыг шалгах дараалал, аргын талаар шийдвэр гаргах
- Нотлох баримтыг шалгахад эсэргүүцэл гаргах тухай шийдвэр гаргах
- Дээрх зүйлийн заалтын дагуу нотлох баримтыг задруулах тухай шийдвэр гаргах (iii)
- Шүүх хурлын огноог тогтоох буюу өөрчлөх, шүүх хурлын үйл явцтай холбоотой бусад шаардлагатай асуудлаар шийдвэр гаргах зэрэг 11 үндэслэлээр хэлэлцэх боломжтой байдлаар зохицуулсан.

Е. Холбооны Бүгд Найрамдах Герман улс²⁹

202-р зүйл Нэмэлт нотлох баримт цуглуулах тухай захирамж

- Шүүх үндсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх эсэхээ шийдэхээс өмнө хэргийг илүү сайн тодруулахын тулд тодорхой нотлох баримт цуглуулахыг тушааж болно. Энэхүү захирамжийг давж заалдах боломжгүй.

202а-р зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар оролцогч талуудтай хэлэлцэх

- Хэрэв шүүх үндсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх талаар авч үзэж байгаа бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урагшлуулахад тохиромжтой гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар оролцогч талуудтай хэлэлцэж болно. Энэхүү хэлэлцүүлгийн үндсэн агуулгыг хэргийн материалд тэмдэглэсэн байх ёстой гэжээ. Үүнээс үзэхэд яг тодорхой ШУХ-ийг

²⁹ Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Эрүүгийн Процессын хууль, https://www.gesetze-im-internet.de/stpo/_23.html, (Сүүлд үзсэн: 2025.11.20)

нэрлээгүй бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэм бурууг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх үүднээс зарим ажиллагааны талаар шүүх өөрөө санаачилгаараа хэлэлцүүлэг зохион байгуулах боломжтой. Энэ талаар хэрэгт тодорхой баримт үлдээх, үлдэх ёстой байна.

1606-р зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар оролцогч талуудтай хэлэлцэх

- Хэрэв энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг урагшлуулахад тохиромжтой гэж үзвэл улсын прокурорын газар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар оролцогч талуудтай хэлэлцэж болно. Энэхүү хэлэлцүүлгийн үндсэн агуулгыг хэргийн материалд баримтжуулсан байх ёстой гэжээ. Үүнээс үзвэл заавал шүүх гэхгүйгээр улсын ерөнхий прокуророос хэргийн оролцогч нартай уулзаж тус хэргийн талаар хэлэлцэх боломжтой зохицуулалт байдаг байна.

166-р зүйл: Шүүхийн хэлэлцүүлгийн үеэр яллагдагчийн хүссэн нотлох баримт

- Хэрэв шүүгч яллагдагчийг байцааж байгаа бөгөөд энэ шалгалтын үеэр түүнийг цагаатгахын тулд тодорхой нотлох баримт авахыг хүсвэл шүүгч шаардлагатай гэж үзсэн хэмжээгээрээ нотлох баримт алдагдах эрсдэл байгаа эсвэл нотлох баримт авах нь яллагдагчийг суллах үндэслэл болж байгаа тохиолдолд ийм шалгалт хийнэ гэжээ.

Холбооны Бүгд найрамдах Герман улсын хувьд яг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, бэлтгэл хангах ажиллагаа гэх нэр томъёо байхгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад улсын ерөнхий прокурор, шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд талуудыг байлцуулж, нотлох баримт болоод бусад нотлох ажиллагаатай холбоотой хэлэлцүүлгийг явуулж болно. Явуулаагүй болон тус хэлэлцүүлгийг явуулсан тохиолдолд шүүгдэгчийн хувьд ашигтай байж болох баримтыг шалгах үүднээс өөрөө шалгадаг зохицуулалттай байна. Энэхүү зохицуулалтаас үзэхэд шүүхэд талуудын мэтгэлцээн гэхээс илүүтэй шүүх өөрөө мөрдөн шалгадаг хэв шинжтэй харагдаж байна.

Ё. Оросын Холбооны улс

234 дүгээр зүйл. Урьдчилсан сонсгол зохион байгуулах журам³⁰

1. Урьдчилсан сонсголыг энэ хуулийн 33, 35, 36 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан талуудын оролцоотойгоор хаалттай шүүх

³⁰ Оросын Холбооны Улсын Эрүүгийн Процессын хууль, https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/343c230528c2e9a60820f8ca2bbb541f6e841187/, (Сүүлд үзсэн: 2025.11.20)

хуралдаанд шүүгч дангаараа оролцох бөгөөд энэ бүлгээс тогтоосон бусад тохиолдолд явуулна.

2. Шүүх хуралдаанд талуудыг дуудах тухай мэдэгдлийг урьдчилсан хуралдааны өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө илгээх ёстой.

3. Урьдчилсан сонсголыг яллагдагч өөрийн хүсэлтээр, эсхүл талуудын аль нэгний хүсэлтээр энэ хуулийн 247 дугаар зүйлийн тав дахь хэсэгт заасан журмын дагуу шүүх хуралдаан явуулах үндэслэл байгаа бол зохион байгуулж болно гэжээ. Тус улсад ШУХ-ийг урьдчилсан сонсгол гэж нэрлэсэн бөгөөд тус хэлэлцүүлэг хаалттай явагдахын зэрэгцээ шүүгч дангаараа шийдвэр гаргах юм. Тус хэлэлцүүлгийг талуудаас хүсэлт гаргасан эсхүл шүүгч өөрийн санаачилгаар явуулах боломжтой байдлаар хууль тогтоогч хуульчилж өгчээ.

4. Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд цаг тухайд нь мэдэгдсэн бусад оролцогчдын алдаа нь урьдчилсан сонсгол зохион байгуулахад саад болохгүй.

5. Хэрэв аль нэг тал нотлох баримтыг хасах хөдөлгөөн гаргасан бол шүүгч энэ хөдөлгөөнд ямар нэгэн эсэргүүцэл байгаа эсэхийг нөгөө талаас нь асууна. Эсэргүүцэл үзүүлээгүй тохиолдолд шүүгч өргөдөл гаргаж, урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулах өөр үндэслэл байхгүй бол шүүх хуралдааныг товлох тухай тогтоол гаргана.

7. Нотлох баримт, эд зүйл нь эрүүгийн хэрэгт хамааралтай бол нэмэлт нотлох баримт, эд зүйл шаардах хүсэлтийг өмгөөлөгчөөс гаргана.

8. Талуудын хүсэлтээр эрэн сурвалжлах ажиллагааны нөхцөл байдал, эрүүгийн хэрэгт баримт бичгийг хураан авах, хавсаргах талаар юу ч мэдэхгүй этгээдийг гэрчээр байцааж болох бөгөөд гэрчийн халдашгүй дархан эрхтэй этгээдийг эс тооцвол.

9. Урьдчилсан хуралдааны үеэр протокол хөтөлнө гэжээ. Талуудын хувьд нотлох баримттай холбоотой санал хүсэлтээ илэрхийлнэ. Нөгөө талаас эсэргүүцэл, гомдол байгаа эсэхийг нягтална. Байхгүй тохиолдолд тус хэлэлцүүлгийг дуусгана. Өөрөөр хэлбэл гомдол, эсэргүүцэл байгаа тохиолдолд шүүх дүгнэлтээ хийх бөгөөд байхгүй тохиолдолд тус хэлэлцүүлгийг дуусгах нь урьдчилсан сонсгол нь талуудын мэтгэлцээний үндсэн дээр шийдвэрлэгддэг гэж хэлж болохоор байна.

235 дугаар зүйл. Нотлох баримтыг хасах хөдөлгөөн³¹

1. Талууд шүүх хуралдаанд танилцуулсан нотлох баримтын

³¹ Оросын Холбооны Улсын Эрүүгийн Процессын хууль https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/920af0a7e79d075670ca3b3c4e7c50047e12ee85/ (Сүүлд үзсэн: 2025.11.20).

жагсаалтаас аливаа нотлох баримтыг хасах хөдөлгөөнийг гаргах эрхтэй. Өргөдөл гаргасан тохиолдолд түүний хуулбарыг шүүхэд өргөдөл гаргасан өдөр нөгөө талд дамжуулна.

2. Нотлох баримтыг хасах хөдөлгөөн нь дараах зүйлийг агуулсан байх ёстой

1) хэргээс хасахыг хүссэн нотлох баримт

2) Энэ хуульд заасан нотлох баримтыг оруулахгүй байх үндэслэл, өргөдлийг нотлох нөхцөл байдал.

3. Шүүгч гэрчийг байцааж, өргөдөлд заасан баримт бичгийг эрүүгийн хэрэгт хавсаргах эрхтэй. Хэрэв талуудын аль нэг нь нотлох баримтыг хасахаас татгалзвал шүүгч эрүүгийн хэрэгт байгаа болон (эсвэл) талуудын ирүүлсэн мөрдөн байцаах ажиллагааны протокол болон бусад баримт бичгийг зарлах эрхтэй.

4. Энэ хуулийн шаардлагыг зөрчиж нотлох баримт олж авсан гэсэн үндэслэлээр батлан хамгаалах байгууллагаас ирүүлсэн нотлох баримтыг хасах хөдөлгөөнийг авч үзэхэд Батлан хамгаалахын танилцуулсан аргументыг няцаах үүрэг нь прокурорт оршино.

5. Хэрэв шүүх нотлох баримтыг хасахаар шийдсэн бол энэ нотлох баримт нь хууль ёсны хүчээ алдаж, шүүхийн шийдвэр эсвэл бусад шийдвэрийн үндэс болгон ашиглах боломжгүй, түүнчлэн шүүх хуралдааны явцад шалгаж, ашиглах боломжгүй болно.

6. Хэрэв эрүүгийн хэргийг шүүх шүүгчдийн оролцоотойгоор шүүх авч үзэж байгаа бол шүүх хуралдаанд оролцогч талууд эсвэл бусад оролцогчид шүүхийн шийдвэрээр хасагдсан нотлох баримт байгаа талаар шүүхэд мэдэгдэх эрхгүй

7. Эрүүгийн хэргийг түүний гавьяагаар авч үзэхдээ шүүх, өмгөөлөгчийн хүсэлтээр хассан нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх асуудлыг дахин шалгах эрхтэй гэжээ. Өөрөөр хэлбэл талуудын аль нэгээс талаас хууль бус аргаар цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтыг хасах, нотлох баримтыг шинээр гаргаж өгөх тохиолдолд тус хэлэлцүүлгийн шүүхээс ямар ажиллагаа хийгдэх талаар дэлгэрэнгүй зохицуулж өгчээ.

236 дугаар зүйл. Урьдчилсан хуралдаанаар шүүгчийн гаргасан шийдвэрийн төрөл³²

1. Урьдчилсан хуралдааны дүнг үндэслэн шүүгч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана

1) Энэ зүйлийн тавдугаар хэсэгт заасан хэрэгт харьяаллын дагуу

³² Оросын Холбооны Улсын Эрүүгийн Процессын хууль, https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/2217689706062e4d989c6b41c31225ac2d71a9d7/ (Сүүлд үзсэн: 2025.11.20).

эрүүгийн хэрэг шилжүүлэх тухай

2) эрүүгийн хэргийг прокурорт буцаах тухай

3) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай

4) Эрүүгийн хэргийг дуусгавар болгох

4.1) энэ хуулийн 25.1-д заасны дагуу эрүүгийн хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 104.4-т заасан шүүхийн торгууль хэлбэрээр аллагадагчид Эрүүгийн хуулийн арга хэмжээ авах тухай

5) шүүх хуралдаан товлох тухай

б) хууль ёсны хүчин төгөлдөр болоогүй ял байгаа тул шүүх хуралдааныг хойшлуулах, өмнө нь Түүний үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн хүний эсрэг түдгэлзүүлсэн ялыг өгөх

7) Энэ хуульд заасан тохиолдолд эрүүгийн хэргийг тусад нь хянан шийдвэрлэх ажиллагаанд хуваарилах, эсхүл салгах боломжгүй болох, шүүх хуралдаан товлох тухай;

8) эрүүгийн хэргийг энэ хуульд заасан хэрэгт нэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгтгэх, эсхүл боломжгүй тухай, шүүх хуралдааны товыг тогтоох тухай гэжээ.

Оросын Холбооны улсын Эрүүгийн процессын хуульд 234 дүгээр зүйлд зааснаар ШУХ-ийг урьдчилсан сонголт гэж нэрлэсэн бөгөөд тус хэлэлцүүлэг хаалттай явагдахын зэрэгцээ шүүгч дангаараа шийдвэр гаргах юм. Тус хэлэлцүүлгийг талуудаас хүсэлт гаргасан эсхүл шүүгч өөрийн санаачилгаар явуулах боломжтой байдлаар хууль тогтоогч хуульчилж өгчээ. Талуудын хувьд нотлох баримттай холбоотой санал хүсэлтээ илэрхийлнэ. Нөгөө талаас эсэргүүцэл, гомдол байгаа эсэхийг нягтална. Байхгүй тохиолдолд тус хэлэлцүүлгийг дуусгана. Өөрөөр хэлбэл гомдол, эсэргүүцэл байгаа тохиолдолд шүүх дүгнэлтээ хийх бөгөөд байхгүй тохиолдолд тус хэлэлцүүлгийг дуусгах нь урьдчилсан сонголт нь талуудын мэтгэлцээний үндсэн дээр шийдвэрлэгддэг гэж хэлж болохоор байна. Мөн хуулийн 235 дугаар зүйлд талуудын аль нэгээс талаас хууль бус аргаар цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтыг хасах, нотлох баримтыг шинээр гаргаж өгөх тохиолдолд тус хэлэлцүүлгийн шүүхээс ямар ажиллагаа хийгдэх талаар дэлгэрэнгүй зохицуулж өгчээ.

VI. Дүгнэлт

Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалт нь анх Англи-Саксоны эрх зүйн бүлд хамаарах орнуудад үүсэж, хөгжлийн явцад Эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад аажмаар рецепци хийгдсэн

байна. Шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн хөгжлийн явцад “хэдийгээр шүүх шударга байж болох ч түүнээс өмнөх шатанд гэмт хэргийг шалгаж, мөрдөн нотлох ажиллагаа нь нэг талыг барихгүй, эрүүдэн шүүлт тулгахгүй, зохиомол хилс хэрэг бүрдүүлж, нотлох баримтыг хуурмаглахгүй байх баталгаа, түүний шударга байдлыг хэрхэн хангах вэ” гэсэн асуудал тулгамдсан. Тухайн асуудлыг шийдвэрлэх мөн шударгаар шүүлгэх эрхийн шаардлагын үүднээс “due process” үүсэн бий болсон байна. “Due process” нь хуульд заасан журмаар ажиллагаа явуулаагүй, процессын явцад оролцогчдын эрхийг зөрчсөн бол тухайн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим бөгөөд түүнийг хангах зөвхөн нэг арга хэрэгсэл бол “шүүхийн өмнөх хэлэлцүүлэг” бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагаа шударга байх явдлыг хангах үүднээс эрүүгийн хэрэг үүсгэх, нотлох баримтыг үнэлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт процессын ажиллагааг алдаагүй явуулах төрөл бүрийн хэлэлцүүлгүүдээс /hearing/ бүрддэг.

Монгол улсын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэх ойлголт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2017 оноос эхлэн тусгайлан нэг үе шат болон хөгжиж эхэлсэн. Өмнө нь 1963, 1987, 2002 оны эрүүгийн процессын хуулиудад шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа гэх нэршилтэйгээр байсан боловч одоогийн зохицуулалт шиг тухайлан нэг үе шат болгосон болон хэлэлцэх асуудлуудыг тодорхойлоогүй байсан юм.

Ардчилсан улсын хувьд дэлхийн нийтийн нийтлэг хандлага, түгээмэл загварыг хүний эрхийг дээдэлсэн улсад тус шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатыг хуульдаа тусгах шаардлагатай бөгөөд зөвхөн энэ шатанд өмгөөлөгч идэвхтэй оролцож, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж агуулагдаж байдаг. Гэтэл практик өмгөөлөгч шүүх хуралдаанд ирдэггүй. Өмгөөлөгч ирээгүй явдал нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй гэж хуульд тусгасан байна. Мөн өмгөөлөгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирсэн боловч бэлтгэлгүй, хийсвэр зүйлс ярьж пассив оролцох тохиолдлууд тохиох болжээ. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг тухайлан нэг үе шат болгосон атлаа заавал дамжин өнгөрөх бус талуудын санал, хүсэлт эсхүл шүүгч өөрийн санаачилгаар хэлэлцүүлэхээр зохицуулах болсон нь эргээд хэлэлцүүлэг хийгдээгүй гэм бурууг эцэслэн шийдвэрлэхэд оролцогчийн эрхийг зөрчсөн болон хэргийг прокурорт буцаах үр дагаврыг бий болгодог. Энэ нь гэм буруугийн хэлэлцүүлгийн шатанд нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчмын хэрэгжилтэд нөлөөлдөг. Шүүгч өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг товлон зарлах нь

тухайн хэргийн материалтай урьдчилсан танилцсан байдаг бөгөөд хэрэгт шаардагдах нотлох баримтыг бүрдүүлэхийг шаардаж, хэргийг прокурорт буцаах нь талуудын мэтгэлцээнд бус яллах хэв шинжтэй шүүхийн дүр зургийг бий болгох болсон.

Гаднын улсын Эрүүгийн процессын хуульд ихэвчлэн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг тусдаа бие даасан, гэм бурууг хэлэлцүүлэх шүүхээс өөр шүүх шийдэх бөгөөд зайлшгүй өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцуулахыг шаарддаг байна. Тодруулбал Бүгд Найрамдах Солонгос улс, Эстони, Япон улсуудад зайлшгүй тус хэлэлцүүлэгт өмгөөлөгчийг оролцуулах шаардлагатай гэж үздэг бөгөөд хэрвээ өмгөөлөгчгүй бол улсаас өмгөөлөгч томилж оролцуулдаг нийтлэг байдал илэрч байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг Болгар улсын хувьд зайлшгүй дамжин өнгөрөх үе шат болгосон бөгөөд Эстони, БНСУ, Япон, ОХУ зэрэг улс нь хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас хамаарч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг талуудын санал, хүсэлт мөн шүүх өөрийн санаачилгаар хэлэлцүүлэх боломжтой байдлаар зохицуулсан байна. Гэхдээ шүүх өөрийн санаачилгаар хэлэлцүүлж буй улсуудын хувьд тус гэм бурууг хэлэлцэх шүүхээс өөр мөрдөн байцаалтын шүүх, гишүүн шүүгч нар хэлэлцүүлэх бөгөөд гэм буруугийн асуудлын талаар энэ шатанд хөндөгддөггүй байна. Дээрх дурдсан улсуудаас Бүгд Найрамдах Хятад Ард улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман улсаас бусад нь талуудын санал, хүсэлтээр хэлэлцүүлгийг хэлэлцүүлэх тохиолдолд бичгээр хүсэлтийг гаргаж нөгөө талдаа гардуулж, хуралд бэлтгэх боломжоор хангасны дараа тус хэлэлцүүлгийг товлон зарладаг байна. Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хувьд яг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, бэлтгэл хангах ажиллагаа гэх нэр томъёо байхгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад улсын ерөнхий прокурор, шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд талуудыг байлцуулж, нотлох баримт болоод бусад нотлох ажиллагаатай холбоотой хэлэлцүүлгийг явуулж болно. Явуулаагүй болон тус хэлэлцүүлгийг явуулсан тохиолдолд шүүгдэгчийн хувьд ашигтай байж болох баримтыг шалгах үүднээс өөрөө шалгадаг зохицуулалттай байна. Энэхүү зохицуулалтаас үзэхэд шүүхэд талуудын мэтгэлцээн гэхээс илүүтэй шүүх өөрөө мөрдөн шалгадаг хэв шинжтэй харагдаж байна. Бүгд Найрамдах Хятад Ард улсын хувьд өөр бэлтгэл хангах ажиллагаа, ШУХ-тэй холбоотой зохицуулалт байхгүй бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүхээс талуудыг дуудаж санал, хүсэлтийг сонсдог байна.

[Ном зүй]

Баабар, *Монголчуудын нүүдэл, суудал* Улаанбаатар: Соёмбо принтинг, 2006 он.

Батаагийн Батцэрэн, “Хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх үндэслэл болохгүй”, 2023 он, <https://legaldata.mn/shiidver/huraangui/view/174>.

Болгар улсын Эрүүгийн процессын хууль, [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2019\)034-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2019)034-e).

Бүгд Найрамдах Солонгос улсын Эрүүгийн процессын хууль, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535.

Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрүүгийн процессын хууль, https://www.chinalawtranslate.com/en/criminal-procedure-law-2018/#_Toc528744293.

Должингийн Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2015 он.

Должингийн Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 2 дахь хэвлэл, Улаанбаатар: Соёмбо, 2012 он.

Должингийн Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, онол практикийн хэлэлцүүлэг, илтгэлийн эмхэтгэл, Улаанбаатар, 2017 он.

Должингийн Баярсайхан, “Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага”, Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, илтгэлийн эмхэтгэл.

Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, “Шүүхээс хэргийг буцаах нь зайлшгүй асуудал уу?”, Эрх зүй сэтгүүл, 51 (3), 2020 он.

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

Монголын хуульчдын холбоо, “Эрүүгийн процессын эрх зүйн зарим тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг, 2017.12.08, <https://www.youtube.com/watch?v=WUyGi8lSV9o&t=1966s>.

Нанзаддоржийн Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар, анхны хэвлэл, Улаанбаатар: Адмон, 2022 он.

Нээлттэй нийгэм форум, Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг: Бодлого судалгааны тайлан, Улаанбаатар: 2020 он, https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf.

Оросын Холбооны Улсын Эрүүгийн процессын хууль, https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/343c230528c2e9a60820f8ca2bbb541f6e841187/.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Эрүүгийн процессын хууль, https://www.gesetze-im-internet.de/stpo/_23.html.

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911–2011, Улаанбаатар: 2012 он.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.

Эстони улсын Эрүүгийн процессын хууль, https://bwcimplementation.org/sites/default/files/resource/EE_Code%20of%20Criminal%20Procedure_EN.pdf.

Япон улсын Эрүүгийн процессын хууль, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2056/en>.

Harvard Law Review, Bail at the Founding, <https://harvardlawreview.org/print/vol-137/bail-at-the-founding/>.

John H. Langbein, The Origins of Public Prosecution at Common Law, https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein_Origins_of_Public_Prosecution_at_Common_Law.pdf.

United States Courts, Federal Probation, https://www.uscourts.gov/sites/default/files/71_2_6_0.pdf?utm_source.com, <https://harvardlawreview.org/print/vol-137/bail-at-the-founding/>, https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein_Origins_of_Public_Prosecution_at_Common_Law.pdf?utm_source=chatgpt.com.

[Abstract]

The Impact of Pre-Trial Hearings in Criminal Proceedings and Proposals for Their Improvement

Enkhzul Enkh-Yalalt

*Bachelor of Laws (LL.B.).
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

The inclusion of pre-trial hearings in the national legal framework has been a positive development. Specifically, during the pre-trial stage, investigative activities are conducted on the basis of the principles of criminal investigation, where investigators and prosecutors hold exclusive authority to collect and consolidate evidence with the aim of determining the guilt of the accused. By contrast, defense counsel's participation during the investigative phase is limited to submitting evidence or filing motions to have particular evidence included in the case file. In order to ensure equality of arms between the parties prior to trial, the legislator introduced the institution of the pre-trial hearing. At this stage, defense counsel has an opportunity to raise exculpatory evidence, challenge procedural irregularities, and point out serious violations of human rights committed during the investigation. This mechanism is designed to ensure balanced and fair preparation for the forthcoming trial on the merits. However, in practice, the implementation and effectiveness of pre-trial hearings have not produced sufficiently positive outcomes. This has given rise to a number of practical concerns among legal scholars and practitioners. Notably, although the pre-trial hearing has been formally established as a distinct procedural stage, it is not mandatory; rather, it may be convened upon the request of the parties or at the judge's own initiative. This approach has, in some cases, resulted in violations of the participants' procedural rights when the hearing is omitted, or in the return of the case to the prosecutor for further investigation. Such practices can adversely affect the application of the presumption of innocence at the trial stage, particularly when the judge, having reviewed the case materials in advance, determines that additional evidence must be obtained and returns the case to the prosecutor. This judicial conduct may blur the boundary between the adversarial and inquisitorial principles, thereby creating the impression of a prosecution-

oriented judiciary rather than one characterized by impartial adjudication.

[Keywords]

Pretrial Hearing, Returning the Case to the Prosecutor, Assigning the Case to the Prosecutor for 60 Days, Concept of Law.